

МОНГОЛ ШАГАЙН ХАРВАА ҮҮССЭН ОН ЦАГИЙН АСУУДЛЫГ ДАХИН НЯГТЛАХ НЬ

Ж. Мөнхдэлгэр
Магистрант
munkhdelgerj@gmail.com

Хураангуй: Тус өгүүлэлд Монгол шагайн харвааны гарал үүслийн талаарх өмнөх судалгааг тоймлон үзэж, зарим эргэлзээтэй баримтуудыг тодруулсан бөгөөд Монгол нутгаас олдсон археологийн хэрэглэгдэхүүн болон Хятадын эртний сурвалж бичгүүдийн мэдээ сэлтэд хайлт хийж, эдгээрт он цагийн харьцуулсан судалгаа болон ангилах, системчлэх зэрэг онолын судалгааны арга зүйг ашиглан тодорхой бус байсан зарим шагайн харвааны гарал үүсэлд холбогдох зарим нэг он цагийг тодруулахыг зорив. Өмнөх судалгаанд шагайн харвааг Их Монгол улсын үе буюу XIII зууны үед үүссэн гэж үзэж байсныг бид археологийн болон бичгийн сурвалжид үндэслэн Хүннү гүрний үе буюу МЭӨ III- МЭ I зууны орчим нүүдэлчдийн дунд хэдийнээ тархсан байжээ гэж үзлээ.

Түлхүүр үгс: Шагай, шагайн наадгай, шагайн харваа, гарал үүсэл

I. УДИРТГАЛ

Шагайн харвааны үүсэл гарлын талаарх түүхийн сурвалж болгон ашиглагдаж буй зарим мэдээг нягтлан үзэхэд: Монголын нууц товчоо [1]-ны 116-р зүйлд: “Тэмүжин, Жамуха хоёр Хорхонаг жубурт нийлэн бууж, эртний анд бололцсоноо дурдалцан, андаа бататгаж нөхөрлөе хэмээлдэв. Анх урьд анд бололцоход, Тэмүжин арван нэгэн настай байхад Жамуха гурын шагай Тэмүжинд өгч, Тэмүжин цутгамал шагай арилжиж, анд бололцож, анд хэмээлдсэн Ононы мөсөнд шагалцахуйд, тэнд анд хэмээлдлээ” гэснийг олонх аман яриа, судалгааны ерөнхий бүтээлүүдэд шагайн харваа, түүний үүсэл, хөгжлийн тухай баримт болгон эш татсаар ирсэн байдаг хэдий ч уг өгүүлэмжид буй шагай болон шагайн наадгай нь бидний өгүүлэн буй шагайн харваа хараахан биш бололтой. Учир нь төв халхад түгээмэл тархсан шагайн харвуул наадааны нэгэн өвөрмөц төрөл болох “Мөсөн шагайн харваа” болох нь “Ононы мөсөнд шагалцахуйд” гэсэн хэсгээс тодорхой харагдахаас гадна “Гурын болон цутгамал шагай арилжсан” гэсэн хэсэгт буй цутгамал шагай гэдэг нь ямар нэг төмөрлөг /алт, мөнгө, гууль, хүрлээр хийж байсан уламжлалтай/ зүйлээр хийсэн шагай бөгөөд мөсөн шагайн харвааны сум болгон ашигладаг байсан зэргээс үзэхэд Монголын нууц товчоонд буй дээрх мэдээг Монгол шагайн харвааны эхэн үеийн баримт гэж үзэх нь эргэлзээтэй байна.

Үүнээс гадна зарим хууч ярианд: “... Хубилай хаан эрийн гурван наадам зохиохдоо шагайг хамт харвуулж байсан тухай Хятадын эртний “Шар

судар”-т тэмдэглэгдсэн байдаг...” [2] тухай өгүүлэмж их тохиолддог. Уг хууч ярианы эх сурвалж болох Хятадын эртний шар судар гэх зохиол нь одоогоор Монгол хэлэнд орчуулагдсан бүтээлүүд дотор тохиолдохгүй бөгөөд Хятад хэлээр буй эсэх нь ч эргэлзээтэй ба ийм сурвалж байхгүй гэж хэлэх ч үндэстэй байна.

Мөн “Халхын түшээт хан Гомбодоржийг өргөмжлөх үед зохиосон эрийн гурван наадамд шагайн харвааг сурын харваатай нэг ижил газар харвуулж, суртай адилаар хүн нэг бүрийн цувааг 20 сум тавиулж байсан тухай Түшээт ханы ургийн бичигт тэмдэглэсэн байдаг ба энэ наадмын шагайн харваанд баруун хүрээний залуу лам Дандар гэдэг хүн түрүүлж байсан” [3] тухай мэдээг зарим ном зохиолд дурьддаг. Гэтэл Түшээт ханы ургийн бичигт шагайн харвааны тухай, тэр бүү хэл Түшээт ханаар Гомбодоржийг өргөмжилсөн (1620-иод он) үед зохиогдсон наадмын тухай мэдээ олдохгүй байна. Мөн тус наадамд түрүүлсэн гэх лам Дандар нь баруун хүрээнийх гэгдэх бөгөөд, баруун хүрээ буюу Шанхын хүрээ нь өгүүлэн буй цаг үеэс 20 гаруй жилийн дараа буюу Өндөр гэгээн Занабазар (1635-1723)-ын арван гурван насны сүүдэр дээр, Эээр Засагчийн тавдугаар (1647) оны гал гахай жил байгуулагдсан ажээ[4]. Энэ мэт эх сурвалж тодорхой бус он цагийн хувьд зөрүүтэй мэдээ сэлтийг цаашид сайтар нягтлан тодруулуштай байна. Түүнчлэн “1700 онд анх зохиогдож, 1912 онд дуусгавар болсон Долоон хошуу наадам дээр харваа намналын олон төрлөөс гагцхүү бай нэхий харвадаг журамтай байсан[5]-ыг түүхч Н.Магсаржавын бүтээл болон “Хаант Оросын элчин төлөөлөгчдийн дурдатгал, түүхэн гэрэл зураг зэрэг олон баримт гэрчилдэг” [6] байна.

II. ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Дэлхийн олон үндэстний дунд шагай хэрэглэх явдал 5000 орчим жилийн өмнө лавтай үүссэн байсан нь эртний Грек, Ром, Египетийн археологийн болон бичгийн дурсгалуудаас тодорхой харагддаг байна.

Монголчуудын хувьд шагайн наадгайн хамгийн олон буюу 200 орчим төрөл зүйлээр тоглодог [7] нь Шинэ чулуун зэвсгийн үеэс одоог хүртэл тасралтгүй мал аж ахуй эрхэлж ирсэнтэй холбоотой төдийгүй шагайн наадгайн уугуул нутгийн нэг гэж үзэж болох юм.

Монгол нутагт малтан судалсан археологийн дурсгалаас үзэхэд одоогоос дөрвөн мянга гаруй жил буюу хүрлийн эхэн үед шагайг хэрэглэж байсан нь тухайн он цагт холбогдох булш, хиргисүүр, тахилын байгууламж болон бууц суурингийн соёлт давхаргад хадгалагдан үлдсэн мал, амьтны

шагайнаас харагддаг. Эдгээрээс түүхэн цаг үе бүрд холбогдох дурсгалуудаас илэрсэн баримтуудаас товч дурьдвал:

Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг, Байрамын давааны орчим малтан судалсан хиргисүүрээс 5348 ширхэг шагай гарснаас богийн шагай 5184 ширхэг, бодын шагай 28 ширхэг, аргалийн шагай 136 ширхэг олджээ [8].

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын сав дахь Баянзүрх уулын 2 дугаар дөрвөлжин булшнаас богийн 15 ширхэг шагай гарсны 12-ыг нь морь байдлаар өрж тавьсан нь анхны байдлаараа илэрч олдсон [9] байна.

Ховд аймгийн Манхан сумын нутаг Тахилтын хотгор дахь Хүннүгийн хүүхдийн булшнаас 60 гаруй богийн шагай [10], Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Наран толгойн Хүннүгийн жирийн иргэний булшнаас 400 гаруй богийн шагай [11], Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг Гол мод-2-ын Хүннүгийн язгууртны 1 дүгээр булшны 3 дугаар дагуулаас 286 ширхэг богийн шагай [12] олджээ.

Орхон аймгийн Жаргалант сумын нутаг, Айрагийн гозгорын 2 дугаар бунхант булшнаас 70 орчим богийн шагай олдсон [13]. Мөн 95 дугаар булшнаас голдоо нүхтэй ногоовтор өнгийн манан чулуугаар урласан жижиг шагай олдсон [14] байна. Айрагийн гозгорын бунхант булшны оршуулгын зан үйл, олдвор хэрэглэгдэхүүн, он цаг тогтоох шинжилгээнд үндэслэн уг дурсгалыг Сяньбигийн үед холбогдуулж гэж үздэг байна.

Архангай аймгийн Өгийнуур сумын нутаг, Талын гурван хэрэм орчимд малтан судалсан Жужаны үед холбогдох нэгэн булшнаас жижгэвтэр арьсан хавтага мэт ууттай цутгасан шагай олджээ. Энэхүү булшинд нилээд чинээлэг, язгууртан шинжтэй эмэгтэй хүнийг оршуулсан болох нь булшны дотоод зохион байгуулалт, дагалдуулсан эд өлгийн зүйлсийн үнэт материал, ур хийц, тоо хэмжээнээс харагддаг байна.

Архангай аймгийн Хашаат сумын нутагт орших Билгэ хаан, Культегиний цогцолбор дурсгалын малтлагын үеэр тахилын чулуун хайрцагнаас богийн болон чонын шагай гарсан байна. 1957 онд нэрт археологич Х.Пэрлээ “Хэнтий аймгийн Навчитийн голын ойр цуварсан 3 түрэг булш малтахад эмээлтэй морь, шавар ваар сав, малын шагай олджээ” [15].

Манай улсад шинжилсэн Уйгарын болон Хятаны үед холбогдох эртний хот хэрмийн үлдэгдлийн соёлт давхаргаас их бага хэмжээгээр бог, бодын болон бусад мал, амьтны шагай олдох явдал түгээмэл тохиолддог байна. 1986 онд нэрт археологич Д.Цэвээндорж нар “Говь-Алтай аймгийн Цогт сумын нутаг Хиргист хоолойд малтсан Хятаны үеийн булшнаас хонины шагай олджээ” [16].

1986 онд археологич Д.Наваан “Улаанбаатарын Сонгинохайрхан дүүргийн Дадарт ууланд гурван Монгол булш малтахад төмөр хутга, үйсэн саадаг, төмөр зэв, хонины шаант, хонины шагай зэрэг зүйлс олджээ” [17], 1989 онд археологич З.Батсайханы “Өвөрхангай аймгийн Хархорин сумын Нарийны ам хэмээх газар малтсан Монгол булшнаас шагай болон бусад эд өлгийн зүйл олджээ” [18].

“Шагай эрхэмлэх зан үйл нь Хүрлийн үеэс Хүннү-Сяньби-Жужан-Түрэг-Уйгар-Хятан-Дундад эртний Монголчуудаар дамжин нүүдэлчдийн дунд шагай хэрэглэх явдал тасралтгүй уламжлагдсаныг харуулж байна” [19] хэмээн судлаач Б.Даваацэрэн дүгнэжээ.

Эдгээр Археологийн дурсгалуудаас олдсон шагайг чухам ямар зориулалтаар ашиглаж байсан нь тодорхой бус хэдий ч шагай эрхэмлэх ёс, шагайг оршуулгын зан үйлд хэрэглэх явдал эртний улбаатай болох нь харагдаж байна. Тэрчлэн зарим шагайн дээр овгийн тамга, дүрс зэргийг сийлсэн байдгаас гадна зарим шагайг тоглож, наадахад зориулан зориуд засаж, янзалсан болох нь мэдэгддэг.

Энэ тухай их эрдэмтэн Л.Түдэв абугай “Шагаа бол Монголчуудад зөвхөн тоглоом наадмын хэрэглэгдэхүүн төдий зүйл биш. Монгол хүнийг эхээс төрөхөд угтаж, эхнэр авах, эрд очиход мөн дагаж, ханан гэрт нь нэгэн насыг элээлцээд, хадан гэрт нь дагалдан оддог бэлгэ дэмбэрлийн сахиус юм” [20] гэжээ.

“Аливаа тоглоом наадгай тухайн ард түмний нийгэм соёлыг харах толь болдог, ёс заншлыг дотроо агуулсан сүнслэг шинжтэй (spirituality), бусад угсаатны бүлгээс өөрийгөө ялгаж ойлгох ойлголт буюу үндэсний ухамсар (identity) болж байдаг” [21] утгаараа шагайн соёлын мөн чанар, зориулалт, гарал үүслийг тодруулах нь Монголчуудын соёлын өв судлалд чухал ач холбогдолтой юм.

“Шагайн тоглоомын анхны хэлбэр нь мал аж ахуй үүсэхээс өмнө ан хийх загвар болгож зээр гөрөөс, бугын шагайгаар “халз харвах”, “бөг чиг харвах” тоглоом зохиож, харвах намнах агуулгатай ардын тоглоом үүсчээ. Учир нь тэр үеийн ахуй, амьдрал ан авд голдуу түшиглэж байсан болохоор амьдралаар загварчилсан тоглоом үүсэх бололцоотой юм” [22] хэмээн Өвөр Монголын судлаач Д.Цагаан агсаны үзсэнийг дэмжихийн хамт шагайгаар тоглох анхны тоглоомууд нь “цөөн тооны шагай”-гаар хээр гадаа хаана ч тоглож болохоор байсан төдийгүй ангийн шагай, тэр дундаа зээр, гөрөөс, бугын шагайг хэрэглэн ан авын шинжтэй, ихэвчлэн харвуул наадаан байсан гэж үзэж болох бөгөөд энэ нь өдгөө хүртэл уламжлагдан ирсэн шагайн наадгайн дэг, ёс заншлаас харагддаг.

Он цагийн хувьд мал аж ахуй үүсэхээс өмнөх, анчин гөрөөчний үед холбогдож болох бөгөөд ан амьтны шагайн олдоц ховор буюу хязгаарлагдмал нөөцтэй холбоотой байсан бололтой. Ховор байх тусам бэлгэдлийн хувьд илүү үнэ цэнийг агуулдаг нь өдгөө ч хадгалагдсаар байна.

Харин “Монголчууд мал аж ахуйтай болсноос хойш шагайн тоо эрс нэмэгдэж, эдийн болон оюуны бүтээл болсон шагайн тоглоомын нэр төрөл олширч, харвах намнахаас илүүтэй ахуй, өрх гэрийн шинжтэй болж, илүү дэлгэрэн хөгжиж, баяр хөөр, наадам цэнгэл оюуны хүртээл болсоор ирснийг энд тэмдэглүүштэй” [23] хэмээн Д.Цагаан дүгнэжээ.

Түүхч П.Дэлгэржаргал, археологич З.Батсайхан нар “Шагайн тоглоом, наадгай нь олон ард түмэн, ялангуяа мал аж ахуй дагнан эрхэлдэг Монгол, Түрэг эсгий туургатны ахуй амьдралын орчин нөхцөлд илүү тохиромжтой байсан учир шагайгаар тоглох олон тоглоомыг санаачилжээ. Түүнчлэн шагайтай холбоотой тоглоом, наадгай одоо ч Монгол, Түрэг ард түмний дунд хадгалагдсаар байгаа ба нэн эртний уламжлалтай ардын тоглоом байжээ” хэмээн шагайн наадгайг Хүрлийн үеэс эхлэлтэй гэж үзсэн [24] байна.

III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Олбог ширдэг дээр тоглох шагайн тоглоомууд харьцангуй хожуу буюу нүүдлийн сонгодог мал аж ахуй үүссэн үетэй холбогдож болох нь шагайн наадгайн дүрэм, дэг ёс, уламжлалуудад тусч үлдсэн нь байна.

Шагайн харвааны хамгийн эртний байж болох уламжлалт хэлбэрүүд соёлын харилцан үйлчлэлд харьцангуй бага өртсөн Монгол орны баруун болон зүүн хэсгийн угсаатны бүлгүүдийн дунд хадгалагдан үлдсэн байна. Эдгээр бүс нутагт зөвхөн шагайн харваагаар зогсохгүй биет бус соёлын олон төрөл эртний хэлбэрээр хадгалагдан буй нь уламжлалт соёлын бусад төрлийн судалгаанд дурдагдсан байдаг.

Жишээлбэл: “1960-аад онд Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт Дөрвөдүүдийн тоглож байсан хавтгай модон дээр шагай овоолон дундаа тавьж, богино хашлага, годил сумаар харван гарцыг нь тооцох харваа” [25], “Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт Дарьгангачуудын шагай харвах гэдэг нэг ам метр орчим модон дээр олон тооны шагай орхиж нясалж байсан наадгай” [26], “Говь-Алтай, Завхан, Ховд, Увс, Баянхонгор аймгийн нутгуудад байх шагайн харвааны эртний хэлбэр” [27], Ховд аймгийн Мөнххайрхан сумын урианхайчуудын зээр харваа, Увс аймгийн олон сумдад буй баядын зээрэн харваа, дөрвөдийн бүг харваа зэргийг дурдаж болохоор байна.

Өнөөг хүртэл хадгалагдан буй дээрх төрлүүд нь шагайн харвааны түүхэн хөгжлийн явцад өөр өөрийн өнгө төрхөөр, тухайн угсаатны бүлгүүдийн

ёс заншлын онцлог шинжүүдийг шингээн халх, боржигин шагайн харвааны соёлын нөлөө үйлчлэлд авталгүй уламжлагдаж ирсэн нь шагайн харвааны үүсэл гарал, анхны хэлбэрийг нэхэн тогтоох судалгаанд чухал ач холбогдолтой юм.

Эртний Монголчуудын талаар өгүүлсэн бичмэл сурвалжуудад шагайн харвааны талаар өгүүлсэн нь харахан олноогүй, судалгааны эргэлтэд ороогүй байсаар өдийг хүрчээ. Харин Монгол соёлын өвийн нэрт судлаач С.Юндэнбат аругайн “Монголын нүүдэлчдийн Соёлын биет бус өв” хэмээх судалгааны бүтээлд буй “Шагайн харвааны үүсэл гарлын тухайд” [28] хэмээх өгүүлэлд Хан улсын үеийн Лю Ань-ий Хуай нань зы хэмээх бичигт өгүүлдэг тун сонирхолтой нэгэн бичгийн мэдээг нийтэлсэн нь гойд сонирхолтой байна. Энд эш татагдсан Хан улсын үеийн Лю Ань-ий Хуай нань зы хэмээх бичгийг “Chinese text project” [29] төслийн хүрээнд цахим орчинд байршуулсан Хятад эх сурвалжаас дэлгэрүүлэн авч үзвэл:

Хятад эх сурвалжуудад “Ху нар яс нясалж” гэсэн өгүүлэмж дараах байдлаар дөрвөн өөр хэсэгт дурдагдсан байна. Үүнд:

1. 淮南子·齊俗訓:故胡人彈骨，越人契臂，中國歃血也。所由各異，其於信一也。(Huáinán zi•qí sù xùn: Gù hú rén dàn gǔ, yuè rén qī bì, zhōngguó shà xuè yě. Suǒ yóu gè yì, qí yú xìn, yī yě).
2. 藝文類聚·盟:胡人彈骨。越人契臂，中國啣盟，所由各異，其於信一也。(Yì wén lèijù•méng: Hú rén dàn gǔ. Yuè rén qiè bì, zhōngguó shà méng, suǒ yóu gè yì, qí yú xìn yī yě).
3. 太平御覽·信:胡人彈骨，越人啣臂，中國啣盟，所由各異，其於信一也。(Tàipíng yù lǎn•xìn: Hú rén dàn gǔ, yuè rén niè bì, zhōngguó shà méng, suǒ yóu gè yì, qí yú xìn yī yě).
4. 太平御覽·盟誓:胡人彈骨，越人鍔臂，中國啣盟，所由名異，其於信一也。(Tàipíng yù lǎn•méngshì: Hú rén dàn gǔ, yuè rén qiè bì, zhōngguó shà méng, suǒ yóu míng yì, qí yú xìn yī yě).

Лю Ань /МЭӨ 179-122/ нь Хан улсыг үндэслэн байгуулагч Лю Бангийн ач бөгөөд Хуайнаны хаан байсан төдийгүй газарзүйч, философич, яруу найрагч зэрэг олон талын мэдлэгтэй маш сониуч хүн байжээ. Тэрээр тухайн үеийнхээ зэрэгцэн оршиж байсан улс үндэстнүүдийн тухай харьцуулан бичсэн нь “Хуай нань зи” хэмээх түүхэн тэмдэглэл зохиолд нь тусгалаа олжээ. Улмаар түүнээс Хятад сурвалжуудад Лю Аний уг тэмдэглэлийг эх сурвалж болгон ашигласаар ирсэн байна.

Эхний өгүүлэмж Лю Аний “Хуа нань зы”-гийн Чи-гийн ёс хэмээх 11 дүгээр бүлэгт “...故胡人弹骨、越人契臂、中国歃血也，所由各异其於信一也...” гэснийг Монголчилбол:

“...тиймээс *Ху нар яс нясалж*, Юувэй нар шивээс шивж, Хятадад амьтны цус хуваан уудаг. Адил бус боловч андгай тавихад зориулагдсан буюу...”.

Хоёр дахь өгүүлэмж болох Тан улс МЭ-ний 618-907 он үеийн “Урлаг, уран зохиолын эмхэтгэл” /МЭ-ний 624 он/-ийн 33 дугаар ботийн “Хүний яам” хэмээх бүлгийн 17, “Мэн”-гийн зургаад,

Гурав дахь өгүүлэмж болох Умард Сүн улс /МЭ-ний 960-1127 он/-ын үеийн Тайпинг Юулан бичиг /МЭ-ний 977-984 он/-ийн боловсон хүчний 71 дүгээр бүлгийн “Захидал” хэсэгт,

Дөрөв дэхь өгүүлэмж болох мөн сурвалжийн боловсон хүчний 121 дүгээр бүлгийн “Амлалт” хэсэгт тус тус Хүннү нарын тухай эхний сурвалжтай ижил байдлаар өгүүлэгджээ.

Уг бичиг нь Хан улсын үеийн Лю Ань /МЭӨ 179-122/-ий бичиж үлдээсэн тэмдэглэл учир энд буй Ху нар (胡人) гэдэг нь Умардын нүүдэлчид буюу Хүннү нарыг хэлж буй хэрэг болно. Няслах (弹)-ыг илэрхийлсэн ханзанд “хурууг нумруулан няслах” гэсэн давхар утга байх бөгөөд яс няслах (弹骨) гэсэн холбоо ханзыг тайлбарлавал “хуруугаа нумлан чангалж шагайг нисгэх” гэсэн утга илэрч байна.

Хуруугаар нумлан хол нисгэж буй нь ямартай ч бөгцөг няслах болон түүнтэй адилтгах ойрын зайн тоглоом бус яалт ч үгүй шагайн харваа гэдгийн илэрхийлэл болох нь харагдаж байгаа төдийгүй өнөөгийн бидний үед уламжлагдан ирсэн “Монгол шагайн харваа” мөн гэж үзэх бүрэн боломжтой байна. Мөн сурвалжид буй нэгэн сонирхолтой баримт нь “Адил бус боловч андгай тавихад зориулагдсан буюу” гэх хэсэг юм. Уг хэсэгт дурдсан өгүүлэмж нь итгэлтэй байх, андгайлах, анд бололцох гэсэн утга байх бөгөөд Хүннүчүүд шагай харваж анд нөхөд бололцдог, эсвэл андлалын харилцаа үүсгэдэг байсан гэж ойлгож болохоор байна.

Яг үүнтэй ижил жишээ Монголын нууц товчооны өмнө дурдсан хэсэгт: *“Анх урьд анд бололцоход, Тэмүжин арван нэгэн настай байхад Жамуха гурын шагай Тэмүүжинд өгч, Тэмүүжин цутгамал шагай арилжисж, анд бололцож, анд хэмээлдсэн Ононы мөсөнд шагалцахуйд, тэнд анд хэмээлдлээ”* хэмээн өгүүлдэг нь шагайгаар андын тангараг тавих явдал Монголчуудын дунд уламжлагдан байсны илрэл юм. Өнөө үед ч гэсэн анд нөхдийн хамгийн бат бөх харилцаа үүсгэдэг уламжлалт наадгай хэвээр байна.

Үүнийг батлах дээрх мэдээ, баримтууд МЭӨ II – МЭ X зууны үеийн Хятад сурвалжуудад олон үе дамжин тэмдэглэгдэн үлджээ.

IV. ДҮГНЭЛТ

Дээрх сурвалжийн мэдээ, археологийн дурсгал зэргээс үзэхэд шагайн харваа нь МЭӨ III зууны үед Монгол нутагт өөрийн өнгө төрх, ёс уламжлалтайгаар нэлээд өргөн хүрээнд тархсан байсныг харуулж байна. Үүнээс өмнө чухам аль үед холбогдохыг нарийвчлан тогтоох боломжгүй байгаа ч одоогоор бидэнд мэдэгдэж буй судалгааны хэрэглэгдэхүүнд үндэслэн:

1. Мал аж ахуй үүсэхээс өмнө шагайн харваа үүссэн байх боломжтой бөгөөд энэхүү таамгийг урлаг судлал, нийгэм соёлын хүн судлал, үгийн гарал судлал зэрэг олон салбар ухаанаар нарийвчлан тогтоох бүрэн боломж байна.
2. Монгол шагайн харваа нь Хүннүгийн үед лавтай үүссэн байсан төдийгүй Хүннүчүүд, түүнээс хойш үеийн Монгол угсаатны дунд ёс заншлын нэгэн чухал илэрхийлэл болон өргөн хүрээнд тархаж, уламжлагдаж ирснийг сурвалжийн олон мэдээ, заалтууд гэрчилж байна.

НОМ ЗҮЙ:

- [1] Дамдинсүрэн Ц. *Монголын нууц товчоо*. –УБ. 2004. 51 х.
- [2] Лхагвасүрэн Г., Батсүх Г., Батхуяг С., Цэвэгмид Г., Басхүү Д., Батсүх Д. *Монгол үндэсний спорт, тоглоом*. –УБ. 2004. 280-284 х.
- [3] Мөн тэнд
- [4] Монголын түүхийн тайлбар толь. <https://mongoltoli.mn/history/h/954>
- [5] Магсаржав Н. *Долоон хошуу наадам*. МУ-ын шинэ түүх. -УБ. 2010. 324, 344 х.
- [6] Мөнхбаяр Х. *Монгол баяр наадмын түүхэн товчоо*. -УБ. 2019. 240 х.
- [7] Түдэв Л. *Монгол шагаа*. -УБ. 2006. 17 х.
- [8] Даваацэрэн Б. *Эртний Монголчуудын шагай эрхэмлэх зан үйлийн уламжлал. Монгол наадгайн соёл*. ОУЭШХ-ын эмхтгэл. -УБ. 2019. 43 х.
- [9] Төрбат Ц., Амартүвшин Ч., Эрдэнэбат У. *Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалууд*. -УБ. 2003. 29 х.
- [10] Наваан Д. *Хүннүгийн булины үнэт шинэ олдвор*. ОУМЭ-ийн V их хурал. УБ., 1992
- [11] Наваан Д., Дэлгэржаргал Л. *1998 оны хээрийн дадлагын тайлан*. МУИС, ААТ. -УБ. 1998. 4 х.
- [12] Эрдэнэбаатар Д., Аллард Ф., Батболд Н., Миллер Б. *Хүннүгийн булинаас олдсон тамгатай шагай*. Түүхийн судлал. Том-XXXIII, Fasc-17, -УБ. 2002. 176 х.
- [13] Даваацэрэн Б. *Айргийн гозгороос илэрсэн шагааны дүрслэл дэхь өгүүлэмж*. Сяньби, Жужаны үеийн түүх соёлын судалгаа. ЭШХ-ын эмхэтгэл.УБ., 2018. 77 х.
- [14] Юндэнбат С. *Монголын нүүдэлчдийн биет бус соёлын өв*. -УБ. 2020. 114 х.
- Г.Лхагвасүрэн, Г.Батсүх, С.Батхуяг, Г.Цэвэгмид, Д.Басхүү, Д.Батсүх “*Монголын үндэсний спорт, тоглоом*” УБТДС, -УБ. 2004. 276 х.
- [15] Сэр-Оджав Н. *Эртний түрэгүүд*. УБ., 1970. 25 х.

- [16] Цэвээндорж Д., Эрдэнэбат У. *Монголын археологийн шинжлэх ухаан*. УБ. 2007. 58 х.
- [17] Наваан Д. *Дундад зууны үеийн монголчуудын оршуулах зан үйлийг судлах асуудалд*. Археологийн судлал. Tomus XI, Fasc.1.УБ. 1986. 3-10 х.
- [18] Цэвээндорж Д., Эрдэнэбат У. *Монголын археологийн шинжлэх ухаан*. УБ. 2007. 65 х.
- [19] Даваацэрэн Б. *Эртний Монголчуудын шагай эрхэмлэх зан үйлийн уламжлал*. Монгол наадгайн соёл. ОУЭШХ-ын эмхтгэл.УБ. 2019. 43 х.
- [20] Түдэв Л. *Монгол шагаа*. УБ. 2006. 89 х.
- [21] Бямбарагчаа Г. *Халх Монголчуудын уламжлалт шагайн харваа тоглоомын тухай*. Угсаатан судлал. УБ. 2020. Том XXVII, Fasc 13. 187 х.
- [22] Цагаан Д. *Монгол хүний язгуур тоглоом-Шагаа*. Хөх хот., 2002. 13 х.
- [23] Мөн тэнд.
- [24] Дэлгэржаргал П., Батсайхан З. *Монголын эртний түүх-I боть: Хүннү*. УБ. 2017. 228 х.
- [25] Батсүх Ш. *Миний мэдэх шагайн харваа*. УБ. 2020. 73 х.
- [26] Сүхбаатар Г. *Даригангын хүүхдийн тоглоом*. Tomus I, Fasc VI, ШУА. УБ. 1962. 5 х.
- [27] Дарамбазар Х. *Монгол үндэсний тоглоомын системийн хөгжлөөс*. Түүхийн судлал. Tomus XIV, Fasc 7. УБ. 1971. 76 х.
- [28] Юндэнбат С. *Монголын нүүдэлчдийн биет бус соёлын өв*. УБ. 2020. 114 х.